

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая. төг/	Шалгуур үзүүлэлт	Хугацаа /I-IV улирал/	Хэрэгжилт	Биелэлт хувь
1	2	3	4	5	6	7
НЗДҮАХ-2.1.8. Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, суурь үзүүлэлтийг ахиулна.						
1	Арга хэмжээ 1. Үндэсний спортын холбоод, бусад спортын холбоодоос Хүй долоон худагт зохион байгуулах үйл ажиллагаануудын тохижилт, үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж		Арга хэмжээний бэлэн байдлыг хангасан тоо	I-IV улирал	Үндэсний спорт хороод, бусад спортын хороодтой хамтран дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж талбайн тохижилт, сандал, тайз, нийтийн бие засах газар, экобус үйлчилгээ хариуцан ажилласан. Үүнд: 2026.05.08, 09-ны өдрийн хугацаанд Хүй долоон худагт зохион байгуулагдсан “Power Expo & Festival-2026” Монголын Авто болон мотоцикл, уран спорт сонирхогчдын наадам, 2026.05.-нд “Морь хурдан уу, дугуй хурдан уу” дугуйн уралдаан 2026.05.04-нд “Мянган долларын дааганы уралдаан” 2026.05.22-нд “Экологийн цагдаагийн марафон” 2026.06.01-нд зохион байгуулагдах “Монгол хүү” хүүхдийн баярын арга хэмжээний бэлтгэл ажил	100
НЗДҮАХ-3.4.1 .Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхолын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж аялалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно.						
2	Арга хэмжээ 1. “Даншиг наадам - Иргэдийн баяр” арга хэмжээг зохион байгуулна.		Хэрэгжилт ийн хувь	III улирал	06 дугаар сарын 21,22-нд болох Хүрээ цам-Даншиг наадмын төсвийг боловсруулан Даншиг наадмын ажлын хэсэгт хүргүүлсэн.	100

1	2	3	4	5	6	7
НЗДҮАХ-4.5.3.Тэр бум мод үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөтэй уялдуулан нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх.						
3	Арга хэмжээ 1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг эзэнжүүлэн, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулна.		Арчилж эзэнжүүлсэн мод, бут, сөөгийн тоо	I-IV улирал	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүй 7 худагт 100 хуйс мод шинээр тарьсан. Тус байгууллагын эзэмшил газарт байгаа нийт 2300 модны арчлалт хамгаалалтыг тухай бүр хийж байна.	100
НЗДҮАХ-5.1. Нийслэлийн хотын засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
4	Арга хэмжээ 1 Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг хэрэгжүүлнэ.		Хэрэгжилт -ийн хувь	I-IV улирал	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.1 -н арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу байгууллагын дотоод үнэлгээг ажлын хэсэг байгуулан, үнэлгээний цахим маягтыг ашиглан байгууллагын мэдээллийг, дотоод үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, чанартай үр дүнтэй зохион байгуулж тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт албан бичгээр хүргүүлсэн.	100
5	Арга хэмжээ 2 Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлнэ.		Хэрэгжилт -ийн хувь	I-IV улирал	Монгол улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн №43 дугаартай тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам” болон дээд газраас баталсан хууль, тогтоол, журам, шийдвэрийг тухай бүр нь судлан хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
6	Арга хэмжээ 3 Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулж, тайлагнаж ажиллана.		Бүрдүүлсэн статистик мэдээллийн сангийн тоо	I-IV улирал	2026 оны 1-р улиралд Нээлттэй мэдээллийн “Shilen.gov.mn” системд хариуцсан чиг үүргийн тухай бүр боловсруулан тайлагнаж 69,04%-н үнэлгээтэй ажилласан.	70

1	2	3	4	5	6	7
НЗДҮАХ-5.1.14. Нийслэлийн хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.						
7	Арга хэмжээ 1 Байгууллагын хэмжээнд 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.		Хэрэгжилт ийн хувь	I-IV улирал	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөг батлуулж, 1-р улирлын байдлаар хэрэгжилт 45 %-тай байна.	100
8	Арга хэмжээ 2. Албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ёс зүйн дэд хорооны 2026 оны ажлын төлөвлөгөөг байгууллагын чиг үүрэгт нийцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.		Хэрэгжилт ийн хувь	I-IV улирал	2026 оны ажлын төлөвлөгөөг байгууллагын чиг үүрэгт нийцүүлэн батлуулсан. Урьдчилан сэргийлэх чиглэлээр ёс зүйн дэд хороо нь 5 сарын 28-нд Төрийн албан хаагчийн ёс зүйн бодлого, үйл ажиллагаа сэдвээр сургалт зохион байгуулсан.	90
НЗДҮАХ-5.2.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.						
9	Арга хэмжээ 1. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, зохион байгуулалт, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллүүдийг ил тод, нээлттэй нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр суртачлах ажлыг зохион байгуулна.		Нийтэд ил тод байршуулс ан мэдээ, мэдээллий н тоо	I-IV улирал	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах мэдээллийг байгууллагын вэб сайтад байршуулсан. Үүнд: - Цалин хөлсний хэмжээ “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрэм - Ажлын байрны сул орон тооны мэдээлэл - Архивын зөвлөмжийн хэрэгжилт 2025 оны Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт Хүй долоон худагт зохион байгуулагдсан мөн цаашид болох арга хэмжээний талаар мэдээлэл бичиж байгууллагын вэб сайтад оруулав. Үүнд: - Наадмаар 56 орны 10 мянган морьтон Монгол улсад цуглана	100

					• Хүй долоон худагт Туурайн тамга цогцолбор баригдана • Дэлхийн адууны өдрийг 7-р сарын 11-13 нд тэмдэглэнэ • Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаанд идэвхтэй оролцоно уу • Дэлхийн адууны өдрөөр дөрвөн байршилд адуу эмчилгээний төв байгуулна. • Дүнжингаравын хурд 2026 Хүй долоон худагт амжилттай болж өндөрлөлөө.	
--	--	--	--	--	---	--

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026 оны 06 дугаар сарын 02

Улаанбаар хот

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая. төг/	Шалгуур үзүүлэлт	Хугацаа /I-IV улирал/	Хэрэгжилт	Биелэлт хувь
1	2	3	4	5	6	7
НХТ-290. “Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний нэгдүгээр шатны зураг төслийг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх,						
1	Арга хэмжээ 1 “Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний нэгдүгээр шатны зураг төслийг боловсруулж, эхлүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлна.		Уламжилсан төслийн тоо	I-IV улирал	“Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний нэгдүгээр шатны зураг төслийг боловсруулж, эхлүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлаагүй байна.	-
НХТ-319. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг нэгтгэн боловсруулах их өгөгдлийн системийг хөгжүүлэн бүтэц, эдийн засгийн зорилтод түвшинг оновчтой тодорхойлж, орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.						
2	Арга хэмжээ 1. Байгууллагын эзэмшилд байгаа хөрөнгийн бүртгэл, тооллогыг зохион байгуулж, өмчийн бүрэн бүтэн байдал, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллах		Зохион байгуулсан тооллого тоо	I-IV улирал	2026 оны эхний хагас жилийн тооллогоны бэлтгэл ажилдаа явагдаж байна.	80